

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 14, 15 дахь хэсэг нэмсүгэй:

“14. Нийгмийн сүлжээнд 13 насанд хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэхгүй байх үүргээ биелүүлээгүй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15. Хориотой, хүүхдэд хортой агуулгын хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14, 15, 16, 17 дахь хэсэг нэмсүгэй:

“14. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологи ашиглан хэрэглэгчийн насыг баталгаажуулан бүртгэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15. 13–16 насны хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй зохицуулалттай нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16. Харилцаа холбооны сүлжээний дугаарыг 16-аас доош насны хүүхдэд түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт баталгаажуулан олгох үүргээ биелүүлээгүй харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17. Насны баталгаажуулалтад шаардлагатай өгөгдөл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй

харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.7 дах хэсгийг 2027 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсаас нийгмийн сүлжээ хэрэглэгч өөрийн насны баталгаажуулалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хийнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ